**ТӨВ АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**XIV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 01 өдөр          Дугаар 03          Зуунмод

"Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийн явцыг дүгнэх тухай

Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийн тайлан мэдээлэл, түүнд Хурлын Хороодоос хийсэн дүгнэлт, Хурлын Төлөөлөгчдөөс гарсан саналыг ХЭЛЭЛЦЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн дэвшүүлсэн 37 зорилт, 173 үйл ажиллагааны хэрэгжилтийн явц 91.7 хувийн гүйцэтгэлтэй тул "Тодорхой үр дүнтэй" гэж дүгнэсүгэй.

2.Таван жилийн Үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлж, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэн, хэрэгжүүлж, гүйцэтгэл, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д даалгасугай.

3.Энэ бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээг хорооны төлөвлөгөөнд тусган батлуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Хороодод үүрэг болгосугай.

ДАРГА          Ц.ЖАМБАЛСҮРЭН

4123010007

# ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ-ТӨВ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН НЭГДСЭН ТОВЧОО

2023.01.23

Зуунмод

| № | Бүлэг | Зорилтын гарчиг | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилт: Үр дүнтэй | Тодорхой үр дүнд хүрсэн | Эрчимжүүлэх шаардлагатай | Хэрэгжилт хангалтгүй | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 100% | 70-99% | 31-69% | 0-30% | |
| 1 | Үндэсний нэгдмэл үнэт зүйл | 1.1. Үндэсний бахархал, эв нэгдэл | 1 | 4 | 4 | - | - | - | 100.00% |
| | | 1.2. Нүүдлийн соёл иргэншилт Монгол | 1 | 2 | 1 | 1 | - | - | 85.00% |
| | | 1.3. Монгол хэл, бичиг | 1 | 2 | 2 | - | - | - | 100.00% |
| 2 | Хүний хөгжил | 2.1. Боловсрол | 1 | 12 | 9 | 1 | 1 | 1 | 89.00% |
| | | 2.2. Эрүүл мэнд | 1 | 9 | 7 | 1 | 1 | - | 92.00% |
| | | 2.3. Гэр бүл | 1 | 5 | 4 | 1 | - | - | 92.00% |
| | | 2.4. Шинжлэх ухаан, технологи, инноваци | 1 | 3 | 2 | - | - | 1 | 77.00% |
| | | 2.5. Хүнд ээлтэй амьдрах орчин | 1 | 3 | 2 | 1 | - | - | 90.00% |
| 3 | Амьдралын чанар ба дундаж давхарга | 3.1. Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл | 1 | 3 | 2 | 1 | - | - | 96.00% |
| | | 3.2. Орлогод нийцсэн орон байр | 1 | 2 | - | 2 | - | - | 80.00% |
| | | 3.3. Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес | 1 | 3 | 1 | 2 | - | - | 83.70% |
| | | 3.4. Эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг | 1 | 2 | 2 | - | - | - | 100.00% |
| | | 3.5. Газрын харилцаа | 1 | 6 | 2 | 3 | 1 | - | 80.00% |
| 4 | Эдийн засаг | 4.1. Өсөлттэй өгөөжтэй эдийн засаг | 1 | 5 | 4 | 1 | - | - | 94.00% |
| | | 4.2. Нийлүүлэгч аймгаас үйлдвэрлэгч аймаг | 1 | 7 | 5 | 1 | - | 1 | 86.00% |
| | | 4.3. Ухаалаг санхүүгийн зах зээл | 1 | 3 | 2 | 1 | - | - | 97.00% |
| | | 4.4. Бүс нутгийн хамтын ажиллагаа | 1 | 2 | 2 | - | - | - | 100.00% |
| 5 | Засаглал | 5.1. Ухаалаг засаглал | 1 | 3 | 3 | | - | - | 100.00% |
| | | 5.2. Ухаалаг бүтэц | 1 | 2 | 2 | - | - | - | 100.00% |
| | | 5.3. Цахим Төв аймаг | 1 | 3 | - | 3 | - | - | 90.00% |
| | | 5.4. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба | 1 | 5 | 3 | 2 | - | - | 99.00% |
| | | 5.5. Хүний эрхийг дээдлэсэн нийгэм | 1 | 2 | 2 | - | - | - | 96.00% |
| | | 5.6. Авлигагүй засаглал | 1 | 1 | 1 | - | - | - | 100.00% |
| 6 | Ногоон хөгжил | 6.1. Хүрээлэн буй орчин ногоон хөгжил | 1 | 9 | 6 | 3 | - | - | 95.00% |
| | | 6.2. Ус-үнэт баялаг | 1 | 6 | 5 | 1 | - | - | 95.00% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 6.3. Хариуцлагатай уул уурхай | 1 | 7 | 5 | 2 | - | - | 94.28% |
| 7 | Амар тайван, аюулгүй нийгэм | 7.1. Зэвсэгт хүчин | 1 | 1 | 1 | - | - | - | 100.00% |
| | | 7.2 Хүн, нийгмийн амар тайван байдал | 1 | 4 | 3 | 1 | - | - | 93.00% |
| | | 7.3. Гамшгийн эрсдэл | 1 | 3 | 1 | 1 | 1 | - | 73.00% |
| | | 7.4.Хууль сахиулах салбарын хөгжил | 1 | 3 | 2 | 1 | - | - | 90.00% |
| | | 7.5 Иргэд, байгууллага үзүүлэх эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээний чанар | 1 | 1 | 1 | - | - | - | 100.00% |
| | | 7.6. Мэдээллийн аюулгүй байдал | 1 | 1 | 1 | - | - | - | 100.00% |
| 8 | Бүс орон нутгийн хөгжил | 8.1. Хөгжлийг тэтгэсэн дэд бүтэц-төв суурингийн хөгжил | 1 | 14 | 6 | 5 | 1 | 2 | 83.00% |
| | | 8.2. Төвийн бүсийн тулгуур төв-Зуунмод хотын хөгжил | 1 | 9 | 7 | - | 2 | - | 89.00% |
| | | 8.3. Төрөлжсөн аялал жуулчлал | 1 | 3 | 1 | - | 2 | - | 67.00% |
| | | 8.4. Тогтвортой хөдөө аж ахуй | 2 | 23 | 19 | 4 | - | - | 96.00% |
| ДҮН | | | **37** | **173** | **119** | **40** | **9** | **5** | **91.77%** |

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.САРАН-ЭРДЭНЭ

НЭГТГЭСЭН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН А.ТУЯАЖАРГАЛ